ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2018 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2018.09.28 Улиастай сум

Нэг: Удирдлага зохион байгуулалтын талаар

- Цагдаагийн байгууллагаас хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтын дагуу 2018 онд 5 бүлэг 60 зүйлээр биелэлт үр дүн тооцох баримт бичгийн жагсаалтыг төлөвлөн цагдаагийн газрын даргаар батлуулан харьяа, хэлтэс, тасаг, ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарт хүргүүлэн ажил арга хэмжээг хэрэгжүүлэн биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.

Төлөвлөгөөнд заасны дагуу хяналтад авч хэрэгжүүлэх, мэдээлэх баримт бичиг бүрийн хэрэгжилтийг ЦБҮАЖ/код-110/-д заасны дагуу ханган ажиллаж заасан хугацаанд холбогдох нэгж, албан тушаалтанд мэдээлэн ажиллаж байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, Тэргүүн дэд, Дэд дарга болон албадын дарга удирдлагаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган биелэлт үр дүнг заасан хугацаанд тайлагнан ажиллаж байна.

- Цагдаагийн газрын даргын зөвлөл батлагдсан төлөвлөгөөний дагуу 18 удаа хуралдаж алба хаагчдын ажлын үр дүнг хэлэлцсэн-15, алба хаагчдаас ирүүлсэн хүсэлт-46, томилгоо-15, иргэдээс ирүүлсэн хүсэлт-2, алба хаагчдын цол, шагналд тодорхойлох-11, алба хаагчдын цалингийн шатлал, удаан жилийн асуудал-5, албаны шалгалтын дүн хэлэлцсэн-16, бүтэц орон тооны асуудал-1, орон тооны бус ажлын хэсгийн ажил дүгнэсэн-4, нийт 115 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.
- 2018 оны гуравдугаар улирлын байдлаар офицерын албан тушаалд 9, ахлагчаар 3 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын дарга, дэд даргын тушаалаар шинээр томилогдсон. Мөн тасгийн даргын албан тушаалд 2 алба хаагч, ахлах албан тушаалд 4 алба хаагч дэвшин томилогджээ. 2018 оны гуравдугаар улирлын байдлаар цэргийн байгын тэтгэвэрт гарсан 9, өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдсөн болон хүүхэд асрах чөлөө авсан 6, албанаас дутагдлаар халагдсан 1, албан тушаал өөрчлөгдөн томилогдсон 34 алба хаагчтай холбоотой тушаал шийдвэрийг холбогдох хууль, ЦБҮАЖ-д заасны дагуу гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар офицерын 1, ахлагчийн 14 орон тоо сул байна.

2018 оны гуравдугаар улирлын байдлаар сургалтын төлөвлөгөөний дагуу мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 48 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 3458 алба хаагч хамрагдсан. Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилт хангах сургалтыг 32 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1758 алба хаагч хамрагдсан. 2018 онд хэрэгжүүлэх албаны сургалтын төлөвлөгөөг 5 бүлэг 18 заалтаар төлөвлөгөө гарган хуваарийн дагуу сургалт явуулан ажиллаж байна. Шинээр батлагдсан хууль, тогтоомж, эрх зүйн актаар офицер, ахлагч нарын мэдлэгийг сорих 30 асуулттай тест 10-ыг боловсруулж шалгалт авсан, мөн “тэсэрч дэлбэрэх бодис илэрсэн”, “хүн барьцаалсан”, “шүүхийн байрны орчинд эмх замбараагүй байдал үүссэн” зэрэг өгөгдлөөр ажиллуулж алдаа дутагдлыг хэлэлцэн дүгнэсэн.

- ЦЕГ-ын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Алба хаагчийн ажлыг үнэлэх журам/код-111/-ын дагуу алба хаагчдыг үндсэн чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын дүн мэдээг ажил дүгнэх үзүүлэлтийн чиг үүрэгтэй нь нийцүүлж сар бүр цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар ажлын үр дүнг хэлэлцэн 2018 оны гуравдугаар улиралд цагдаагийн газрын даргын 3 удаагийн тушаалаар 34 /давхардсан тоогоор/ алба хаагч, ажилтны цалинг 5-20 хувиар нэмэгдүүлж, 4 алба хаагчийн цалинг 5-20 хувиар хасаж олгосон.

Алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цагдаагийн ерөнхий газрын 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Тосонцэнгэл сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн конторын барилгын ажил төлөвлөгөөнд заасан гүйцэтгэлтэйгээр явагдаж байна. Сумдын хэсгийн төлөөлөгч нарыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл

бололцоогоор хангах зорилгоор Цагдаагийн газрын дарга, сумын Засаг дарга, хэсгийн төлөөлөгч нарын гурвалсан гэрээний дагуу шаардлагатай бензин шатахуун, холбооны хэрэгсэл, бичиг хэрэг болон хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллаж амьдарч буй ажлын байр/кабон/-ны цахилгаан, дулааны тогтмол зардлыг шийдвэрлэхэд сум орон нутгаар дэмжүүлэн ажиллаж байна. Мөн Баянтэс сум дахь Цагдаагийн байр/кобан/-нд засвар хийж тохижуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус аймгийн Их-Уул, Сонгино сумд баригдах замын цагдаагийн хяналтын постын барилга барих тендерийн сонгон шалгаруулалтыг зарлан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг шалгаруулж барилгын ажил төлөвлөгөөний дагуу 60 хувьтай байна. Барилгын ажлын гүйцэтгэлд сум дундын Цагдаагийн хэлтэс, тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нар өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн газрын халааалтын зуухыг Цагдаагийн ерөнхий газрын хөрөнгөөр шийдвэрлүүлэн зуухны шинэчлэлтийг хийж ашиглалтад оруулан хэвийн ажиллагааг хангасан.

“Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах” ажлын хүрээнд орон нутгийн хөрөнгө орлогоос 140 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 60 сая төгрөг гаргаж 200 сая төгрөгийн төсвөөр Улиастай сумыг камержуулахаар 2018 үндсэн чиглэлд тусгагдсанаар камержуулах ажлыг “Төгс электроникс” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өглөө. 56-н цэгт 112 камер байршуулж бүрэн ашиглалтад өгснөөр Улиастай сумын нутаг дэвсгэрт камерын хяналт тогтоон ажиллаж байна.

Цагдаагийн газрын ногооны талбайд энэ оны 6 дугаар сард 3тн төмс тариалан услалт арчилгааг хийж энэ оны 9 дүгээр сард 8тн төмс хураан авч ажиллаа.

- 2018 оны гуравдугаар улирлын байдлаар малчдын бүлэг-51, иргэдийн сайн дурын санаачилгын бүлэг/ хөршийн хяналтын бүлэг/-4, оюутан цагдаа-4, “Өсвөрийн сэргийлэгч” бүлэг-32, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хүүхэд хамгааллын хамтарсан баг 30, School police эргүүлийн 19, нийт 140 иргэдийн үүсгэл санаачилгын бүлэгт 2280 хүн ажиллаа. Монгол Улсын Их сургуулийн Завхан сургууль, Соёл урлагийн их сургуулийн харьяа Хөгжим бүжгийн коллеж, Политехникийн коллежуудын 4 оюутны зөвлөлүүд, малчдын 3 бүлгийг тус бүр 1 удаа мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа. "Хариуцлагатай хамтарсан баг-2018" хөтөлбөрт арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж буй Хамтарсан багийг чадавхжуулах сургалтыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтарч Тосонцэнгэл сумд зохион байгууллаа. Уг сургалтад Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн сумдын Хамтарсан багийн гишүүд, мөн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, багийн засаг дарга, багийн эмч тэргүүтэй гэр бүл, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг хамруулсан. Мөн Улсын их хурлын дэд дарга Я.Санжмятавын санаачлан 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс мөн сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан “Бид Чингисийн үр сад-Зөв тэмүүлэл-Эх оронч манлайлал” арга хэмжээний хамгаалалт зохицуулалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Завхан аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/12 дугаартай захирамжаар “Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, зохих дүгнэлт өгч, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн урт болон богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгээс хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/210 дугаартай захирамжаар олон нийтийн цагдаагийн ажилтнуудын урамшуулал, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлүүлэн орон нутгийн хэмжээнд 5 олон нийтийн цагдаа ажиллуулж байна.

- Тус цагдаагийн газраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх нэгдүгээр үе шатны салбар төлөвлөгөөг гарган батлуулж хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажиллаж байна. Биелэлтийг хагас жилээр тооцон холбогдох нэгж, албан тушаалтанд заасан хугацаанд хүргүүлсэн. Цагдаагийн газраас орон нутгийн Айр-1 телевиз, Завхан сонины газартай тус тус хамтран ажиллах гэрээ

байгуулан Авлигын эсрэг сэдэвтэй шторк зурагт хуудсыг иргэдэд сурталчлах ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сар бүрийн 3-р долоо хоног бүр тогтмол мэдээлэл хийж ажилласан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн газраас зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдрөөр иргэдийн санал хүсэлтийг авах, мэдээлэл авах утас, авлигын хор хөнөөлийн талаарх зурагт хуудас бэлтгэн иргэдэд тараасан.

Шинэчлэн батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам бүрийг алба хаагчдаар судлуулж, долоо хоногийн 4 дэх өдрийн өглөөний мэдээллийн дараа алба хаагчдад мэдээлэл өгч ажиллаж байна. Тус аймаг нь 2018-2020 оны хооронд Авилгагүй аймаг дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна, уг дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа ажил арга хэмжээг тухай бүрд нь аймгийн нэгдсэн сайт болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр иргэдэд сурталчлан ажиллаж байна. Мөн Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авилгагүй аймаг дэд хөтөлбөрийн талаар иргэдэд сурталчлах, Авилгын эсрэг сэдэвтэй шторк зурагт хуудсыг иргэдэд сурталчлах ажлыг орон нутгийн Эйр-1 телевизээр давхардсан тоогоор 39 удаа нэвтрүүлсэн. Цагдаагийн алба хаагчийн авилга, хүнд сурталтай холбоотой мэдээ мэдээллийг хүлээн авах /126/ утасны дугаарыг бичсэн хэвлэмэл хуудас тарааж, Цагдаагийн газарт цагдаагийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авах тусгай 70194519 дугаарын утсыг нээн ажиллуулж байна.

Тус цагдаагийн газрын цахим хуудсыг урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ж.Баярмаа хариуцан ажиллуулж байна. Уг цахим хуудас дахь мэдээллүүдийг тогтмол шинэчлэн цагдаагийн газраас зохион байгуулж байгаа олон нийтийн болон бусад арга хэмжээг тогтмол сурталчлан ажиллаж байна. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын тендер, худалдан авалтын арга хэмжээ болон бусад 67 мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд хугацаанд нь тогтмол байршуулсан.

- 2018 оны гуравдугаар улирлын байдлаар алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 2 гомдол мэдээлэл ирүүлсэнд албаны шалгалтын дугаар олгож шалгаж шийдвэрлэсэн. Үүнээс 1 алба хаагчид цол бууруулах, 1 алба хаагчийн үйлдэлд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сахилгын шийтгэл оногдуулсан тоо ижил үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдолд бүртгэлээр хяналт тавьж хугацаанд нь шийдвэрлэж байна.

Цагдаагийн газар, тасгийн дарга нараас алба хаагчдын цаг ашиглалтад тавих хяналтыг өдөр бүр хэрэгжүүлэн Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Завхан аймагт 2018 оныг “Төрийн алба хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах” жил болгон зарласан, аймгийн засаг даргаас дэвшүүлсэн төрийн алба хаагчийн баримтлах 9 зарчимтай уялдуулан ажиллаж байна. 2018 оны нэг, хоёр, гуравдугаар улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг Цагдаагийн газар болон Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст зохион байгуулж сахилга хариуцлагыг сайжруулах талаар удирдлагаас болон алба хаагчдаас санал санаачилга, зөвлөмж гарган танилцуулж улирал бүрийн сахилгын зөвлөгөөнөөс гаргасан уриалга, хамт олны саналыг хэрэгжүүлэн ажиллаж байгууллагын соёлыг төлөвшүүлэх, харилцааны соёлыг эрхэмлэн ажиллахыг алба хаагч бүрд үүрэг болголоо.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах” тухай 01 дүгээр албан даалгаврын 2018 онд хэрэгжүүлэх 25 заалт бүхий салбар төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг тооцож улирал тутам Цагдаагийн Ерөнхий Газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Цагдаагийн газрын даргаас алба хаагч бүрээс бичгээр авилга, ашиг сонирхлоос ангид байх, албаны нэр хүнд, ёс зүй, шударга ёс, удирдлагын манлайллыг эрхэмлэн ажиллах талаар баталгаа авсан.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас энэ оны 3/1781 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийг Цагдаагийн газрын нийт алба хаагчдад танилцуулан архи, согтууруулах ундааны хор уршгийн талаар жишээ дурдан хэлэлцэж цаашид хэрэглэхгүй байх баталгаа авсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас энэ оны 9 дүгээр сарын 3-ны өдөр өгсөн үүрэг, Тэргүүн дэд даргын 2018 оны 2/359 дугаартай мэдээлэл, үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 3/4020 болон 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 3/5234 дугаартай үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг тус тус боловсруулан баталж, сум дундын Цагдаагийн хэлтэс, тасагт хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус аймгийн 24 сумын ард иргэдээс цагдаагийн алба хаагчийн ажлын хариуцлага, сахилга, харилцааны соёлын талаар санал асуулга авч сум бүрээр дүгнэн, судалгаанд үнэлэлт дүгнэлт хийж алба хаагчдад цагдаагийн газрын даргаас зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.

- Алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, цагдаагийн газрын гадаад дотоод орчинг засварлах, сүүлийн үеийн дэвшилтэд техник хэрэгслээр хангах чиглэлээр бодлого боловсруулан ажиллан тус цагдаагийн газар нь 2018 оны эхний 9 сарын байдлаар урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1.931.997.300 төгрөгийн санхүүжилт авч, үүнээс: цалинд 998.769.221 төгрөг, НДШ-д 41.680.000 төгрөг, гэрэл цахилгааны зардалд 15.616.013 төгрөг, түлш халаалтын зардалд 28.812.429 төгрөг, цэвэр бохир усны зардалд 4.000.030 хоолны зардалд 14.130.255 төгрөг, бичиг хэргийн зардалд 7.865.160 төгрөг, тээвэр шатахууны зардалд 106.583.372 төгрөг, шуудан холбооны зардалд 7.878.013 төгрөг, томилолтын зардал 21.143.200 төгрөг, урсгал засварын зардалд 5.782.320 төгрөг зарцуулж ажилласан. 2018 онд батлагдсан төсвийг зарцуулж хоолны зардал 2.866.625 төгрөгийн өглөг үүссэн нь 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хоолны мөнгө нэмэгдсэнтэй холбоотой юм.
- Тус Цагдаагийн газраас гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2018 оны А/26 дугаар тушаалаар “Түдгэлзүүлснээс сэргээсэн болон эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэн шалгаж шийдвэрлэх ажлын хэсэг”-ийг байгуулж ажилласан. Ажлын хэсгийн ахлагчаар цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, нарийн бичгийн даргаар эрүүгийн ахлах мөрдөгч, гишүүдэд Эрүүгийн цагдаагийн тасаг, мөрдөн байцаах тасаг, хэрэг бүртгэх тасаг, сум дундын цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгийн дарга, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа, хэсгийн байцаагч, багийн цагдаа нараас бүрдсэн. Ажлын хэсгийн гишүүдийг эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэсгийн байцаагч, багийн цагдаа гэсэн бүрэлдэхүүнтэйгээр баг болгон ажиллуулсан нь гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхээр 4-5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй баг нэгдсэн удирдлагатайгаар ажиллаж байгаа нь гэмт хэргийг шуурхай илрүүлэх, шалгаж шийдвэрлэх, хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд чухал үр дүнгээ өгсөн шинэлэг ажил, арга хэмжээ болж гэмт хэргийн илрүүлэлт гуравдугаар улирлын байдлаар 65.6 хувьтай тооцогдлоо. Багийн ажлыг гэмт хэргийн илрүүлэлтээр үнэлж урамшууллыг багийн гишүүн бүрд олгох, хариуцлагыг мөн хамтын зарчмаар хүлээх нөхцөлийг бүрдүүлсэн нь алба хаагчдын идэвх зүтгэлтэй, шуурхай ажиллахад дэмжлэг болж байна. Мөн “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт-2018” арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын тушаалаар томилон, ажил арга хэмжээг ажлын хэсгээс удирдан зохион байгуулан дүнг 7 хоног бүр гарган цагдаагийн газрын даргад танилцуулан ажиллаж мэдээ тайланг заасан хугацаанд дээд байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Эрүүгийн цагдаагийн тасгаас 2018 оны эхний 09 сарын байдлаар 55 материалаар 190,280,000 /Нэг зуун ерэн сая хоёр зуун наян мянган/ төгрөгийн хохиролтой,59 холбогдогчтой, 55 хэрэг, үйлдлийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт шилжүүлж, буюу эрүүгийн тасгийн алба хаагчид шалгаж ажилласан.

Эрэн сурвалжлах чиглэлээр олж тогтоосон хүн, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд-9, мал, эд зүйл 77-г олж тогтоож эрэн сурвалжлалт зогсоосон.

2018 оны эхний 09 сарын байдлаар эрүүгийн цагдаагийн тасаг нь 203 гомдол, мэдээлэл хүлээн авч, 108 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгаж шийдвэрлэсэн, 12 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 2 гомдол мэдээлэл үлдэгдэл ажиллагаанд байна.

Зөрчлийн шинжтэй 84 гомдол мэдээлэл хүлээн авснаас 82 мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн үлдэгдэл 2 байна.

Тасгийн хэмжээнд нийт түдгэлзүүлснээс сэргээсэн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 54 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, прокуророос ирүүлсэн даалгавар тогтоолын биелэлтийг тооцож 7 хэргийг шийдвэрлэж одоо үлдэгдэл 47 хэрэгт ажиллагаа хийж байна.

Эрүүгийн цагдаагийн тасгаас энэ хугацаанд “Хяналт сүлжээ”, “Илрүүлэлт-1”, “Сан тулгалт”, “Бүртгэл хяналт ”, “Орон нутаг”, “Устгал”, “Маршрут”“ Гивлүүр”зэрэг хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан байна.

Цагдаагийн байгууллагын “Эрэн сурвалжлах ажлын журам”/код-229/-ыг хэрэгжүүлэх, “Эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” сангийн бүртгэлийн үйл ажиллагаа, ашиглалтын талаар бие бүрэлдэхүүнд 8 цагийн албаны сургалтыг зохион явуулж, санд эрэн сурвалжлалт зарлан мэдээлэх эрх бүхий офицер алба хаагч нэг бүрийг сантай ажиллуулж “ASAP” санд зарлагдсан мэдээллийг хянаж, бүртгэж гаргасан зөрчлийг тухай бүр нь засуулж ажиллаж байна.

Хэрэг бүртгэх мөрдөн байцаах эрхтэй алба хаагч нар дээр шалгагдаж байгаа иргэдийн мэдүүлэг авах хэсгийн биеийн байцаалтын доод талд эрэн сурвалжлах “ASAP” сангийн тулгалт гэсэн асуултыг нэмж оруулан эрэн сурвалжлах сангаас хайлт тулгалтын хийж ажилласны үрд дүнд “ASAP” санд зарлагдсан 5 оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг олж тогтоолоо.

2018 оны эхний 09 сарын байдлаар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиар алба хаагчдад нэг цагийн сургалт орж ажилласан. Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд зохион явуулах Гэрч хохирогчийг хамгаалах хууль, журмын хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж ажиллаж, тус хэлтсээс ирүүлсэн зурагт хуудсыг хүн ам олноор цуглардаг албан байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбарт байршуулж, видео шторкийг орон нутгийн Завхан телевизээр сурталчлан ажилласан байна.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр энэ оны эхний 09 сарын байдлаар байдлаар нийт 8холбогдогчтой 35,5 сая төгрөгийн хохиролтой 8 гэмт хэргийг илрүүлэн Хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж яллагдагчаар татах саналтай прокурорт шилжүүлсэн.

Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

Гомдол мэдээллийн талаар: 2018 оны эхний 9 сарын байдлаар тус цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасаг нь иргэд, аж ахуйн байгууллагаас 68 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн ба гомдол, мэдээллийг хуулийн анхны хугацаанд 100 хувь шалгаж шийдвэрлэсэн байна.

Нийт шалгасан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 48 буюу 68,2 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 18 буюу 37,7 хувийг нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 3.4 хувь буюу 2 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн.

Гэмт хэргийн талаар: 2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 103 хүнд холбогдох 92 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгаснаас 32 хэргийг ЭХХШТХ-ийн 32.5.1.1, 1.5-1.1.-ээр хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлж, 28 хэрэгт нь эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал прокурорт хүргүүлж яллагдагчаар татан шалгаж, 46 хүнд холбогдох 42 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн. Ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 10 хэргийн үлдэгдэлтэй байна.

Бусад газраас харьяаллын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татан шилжүүлэн ирүүлсэн 39 хэргийг хүлээн авч мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгаснаас 15 хэргийг бусад хэрэгт нэгтгэн шалгаж 31 хүнд холбогдох 22 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж, 2 хэргийг бусад газарт харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн. Ажиллагаанд мөрдөн байцаалтын хэргийн үлдэгдэлгүй байна. Нийт үлдэгдэл мөрдөн байцаалтын 10 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгаж байна. Нийт мөрдөн байцаалт явуулсан хэргийн 90,4 хувийг хуулийн анхны хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 450,1 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 232,5 сая төгрөгийн хохирол нөхөн төлүүлж хохирол нөхөн төлөлт 54,1 хувьтай гарсан. Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад яллагдагчийн хувьд ногдох 210,7 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжлэн ажилласан.

2018 оны 9 сарын байдлаар яллах дүгнэлт үйлдүүлэхээр шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлсэн 51 хэрэгт мөрдөгчийн мэдэгдэл бичиж 48 мэдэгдлийн хариуг авч ажилласан. 17 мэдэгдлийн чиглэлээр мэдэгдлийн хариуг газар дээр нь очиж шалгаж зааварчилсан. 3 мэдэгдлийн ирүүлэх хугацаа болоогүй байгаа болно.

Тасгийн даргаас мөрдөгч нарт ЭХХША-тай холбоотой 6 зааварчилга, мөрдөгч нарын шалгаж буй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нийт 45 хэрэгт даргын даалгавар, зааварчилга бичиж 42 зааварчилга, даалгаврын биелэлтийг тооцож ажилласан. Гэмт хэргийн шинжтэй нийт 14 дуудлагад мөрдөгчийн хамт очиж хэргийн газрын үзлэгийг удирдан зааварчилж явуулсан болно.

2018 оны эхний 9 сарын байдлаар хулгайлах гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдсан хэргийн холбогдогч нарт таслан сэргийлэх арга хэмжээг зөв оновчтой авснаар мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан яллагдагч байхгүй байна.

Урд оны түдгэлзүүлсэн 1 хэрэгтэй байсныг 2018 оны 01 дүгээр сард сэргээн эрүүгийн 1723000020003 дугаартай Загдсүрэнгийн Мягмарцэрэнд холбогдох ЭХХШТХ-ийн 31.14-1.2 түдгэлзүүлсэн 1 хэрэг байсныг 2018 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр оргодлыг олж баривчлан хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж шийдвэрлэсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Мөрдөн байцаах, Эрүүгийн цагдаагийн албаны даргаас эрүүгийн хэрэгт хяналт тавих журам” / код- 328/ -ын 328.5.1, 328.5.2, 328.5.3 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаж, шүүх, прокуророос нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэргийн бүртгэл, цагдан хорих болон Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээ авсан яллагдагчийн бүртгэл, түдгэлзүүлсэн хэргийн бүртгэл болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн бүртгэлийг тус бүрд нь нээн бүртгэлээр хяналт тавьж ажиллаж байна.

Тасгийн даргын зүгээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нийт 45 хэрэгт даргын зааварчилга бичиж биелэлтийг хангуулж ажилласан. Гэмт хэргийн шинжтэй нийт 21 дуудлагад мөрдөгчийн хамт очиж хэргийн газрын үзлэгийг удирдан зааварчилж явуулсан болно.

Прокурор, Мөрдөгч нарын хамтарсан зөвлөгөөнийг сар бүр Цагдаагийн газар, Прокурорын байгууллага дээр ээлжлэн зохион байгуулан мөрдөгч нарын гаргаж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргаж байгаа алдаа, зөрчлийн талаар хэлэлцэн шийдвэрлэх арга замыг тодорхойлон ажилласнаар алба хаагчдын гаргаж байгаа алдаа, зөрчил тодорхой хэмжээгээр буурсан.

Цагдаагийн газар, аймгийн Прокурорын газрын хамтарсан зөвлөгөөнийг Цагдаагийн газрын дарга, аймгийн Прокурорын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөр аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газрын Эрүүгийн мөрдөгч, Хэрэг бүртгэх албаны мөрдөгч, Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчдийн хамтарсан зөвлөгөөнийг зохион явуулж эхний улиралд хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ болон цаашид авч хэрэгжүүлэх арга замын талаар болон Шүүх, прокуророос буцсан хэргийн шалтгаан нөхцөл, цаашид анхаарах зүйлийн талаар хэлэлцэж зөвлөгөөнөөс шийдвэр гарган хэрэгжүүлэн ажилласан.

Мөн 2018 оны 04 дугаар сарын байдлаар шүүхээс буцсан 1, прокуророос буцсан 2 эрүүгийн хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, тогтоох ажлын төлөвлөгөө гарган, алба хаагчдыг сурган дадлагажуулах, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Завхан аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газрын хамтарсан “Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, гарч буй хүндрэл бэрхшээл, гарах арга зам Шүүхээс буцаж байгаа хэргийн шалтгаан, үндэслэл цаашид анхаарах асуудал”-ын талаар Цагдаагийн газрын хурлын зааланд 3 цагийн уулзалт, ярилцлага байдлаар арга хэмжээ зохион байгуулсан.

Сар бүр прокурор, мөрдөгч нарын хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж тухайн сард шийдвэрлэх хэрэг болон өмнөх сарын шийдвэрлэх хэргийн биелэлтийг тооцож ажиллаж хэвшсэн.

Мөн 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Прокурор, мөрдөгч нарын хамтарсан зөвлөгөөнийг Цагдаагийн газарт зохион байгуулж ЭХШШТХ-ийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар зөвлөгөөнийг зохион байгуулсан.

2018 оны эхний 9 сарын байдлаар прокурорын тогтоолд устгахаар заагдсан эрүүгийн 25 хэрэг, 1 гомдол мэдээллийн 530 ширхэг эд мөрийн баримтыг устгаж ажилласан.

Одоо тус Цагдаагийн газрын эд мөрийн баримт хадгалах өрөөнд 19 эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар тооцогдсон 84 ширхэг эд мөрийн баримт хадгалагдаж байна.

Эрүүгийн хэргийн эд мөрийн баримт, барьцааны эд зүйл, мөнгө, хураан авсан болон битүүмжилсэн эд хөрөнгийг хүлээн авч, шийдвэрлэсэн тухай бүртгэлд урд бүртгэгдсэн болон 2018 оноос хойш хураагдсан эд мөрийн баримтуудыг шинэчлэн бүртгэсэн, эд мөрийн баримтын онцлог шинж тэмдэг, тоо ширхэг, хэргийн дугаар, эд мөрийн баримтаар тооцсон огноо, хэзээ хэрхэн шийдвэрлэсэн эсэхийг бүрэн тэмдэглэж, шаардлагын дагуу бүртгэлжүүлэн ажилласан. Эд мөрийн баримтын өрөөний дотор хяналтын камер суурилуулж хаалгыг шинэчлэн төмөр хаалга, хамгаалалт хийлгүүлсэн.

Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

2018 оны 09 сарын 25-ний өдрийн байдлаар иргэд, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 35 гомдол, мэдээлэл хүлээн авч, 7 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 23 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 4 гомдол, мэдээлэлд мөрдөн байцаалтын хэрэг үүсгэж, 1 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэсэн.

Хэрэг бүртгэлтийн 42 хэрэг шалгаж, 24 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 10 хэргийг хааж, 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн бөгөөд одоо ажиллагаанд 7 хэрэг шалгагдаж байна.

Мөн энэ хугацаанд мөрдөн байцаалтын 44 хэрэг шалгаж, 41 хэргийг шүүхэд шилжүүлж, 1 хэргийг бусад хэрэгт нэгтгэн шийдвэрлэсэн. Одоо ажиллагаанд 2 эрүүгийн хэрэг шалгагдаж байна.

Хэрэг бүртгэх албаны даргын 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/16 дугаар тушаалаар тасаг, нэгжүүдийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг баталж өгсөн бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 60 хувиас доошгүйг нөхөн төлүүлж, битүүмжлэн хамгаалсан байхаар шалгуур үзүүлэлтийг тогтоосон.

Шалгуур үзүүлэлт болон Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад иргэд, хуулийн этгээдийн нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгө битүүмжлэх, хамгаалах ажлын үр дүнг сайжруулах чиглэлээр тасгийн мөрдөгч, сум хариуцсан эрүүгийн мөрдөгч нарт 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр тасгийн даргын 41/620, 41/621 тоот зөвлөмж боловсруулж хүргүүлсний үр дүнд хөрөнгө битүүмжлэх, хамгаалах ажлын үр дүн сайжирсан.

Эхний 9 сарын байдлаар гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид учирсан 32,6 сая төгрөгийн хохирлоос 20,7 сая төгрөг буюу 65 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн.

Мөн 39,5 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн байна.

Хэрэг бүртгэх тасгийн орон тоо бүрэн бөгөөд тасгийн дарга 1, ахлах мөрдөгч 2, нийт 3 орон тоотой ажиллаж байна.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 13 үйлдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 нэгж буюу 26 % буурсан байна. Олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 15 бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9 нэгжээр буюу 1,5 дахин өссөн байна, Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 52 бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8 нэгжээр буюу 6,5 хувиар буурсан байна.2018 оны гуравдугаар улирлын байдлаар 106 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал ижил түвшинд байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 3 дугаар улирлын байдлаар зөрчлийн шинжтэй 5858 гомдол мэдээлэл хүлээн авч, 93 зөрчлийн хэрэг нээж, харьяаллын дагуу 3 материалыг шилжүүлж, материалыг хүлээн авахаас татгалзсан, 613 материалыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Нийт 2159 зөрчил илрүүлж, 1901 иргэнийг 277.928.6 /хоёр зуун далан долоон сая есөн зуун хорин найман мянга зургаан зуун/ төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, танхайрсан, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон болон бусад зөрчил гаргасан 106 хүнийг шүүгчийн захирамжаар 7-30 хоногоор баривчлах шийтгэлийг эдлүүлсэн.

Цагдаагийн Ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 2/24 дугаартай ажлын чиглэл, үүргийн дагуу тус цагдаагийн газарт иргэдээс өөрийн хүсэлтээр устгуулахаар ирүүлсэн 8 галт зэвсгийг Шүүхийн шинжилгээний албанд хүлээлгэн өгч дүгнэлт гаргуулан 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 45/152 дугаартай тоотоор хүргүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар шинээр 18 галт зэвсэг бүртгэн гэрчилгээ олгосон байна.

Улиастай сумын нутаг дэвсгэрт хөдөлгөөнт эргүүлийг 6 багт 4 чиглэл, сумд 1-2 чиглэлд давхардсан тоогоор эргүүлд 240 офицер, 4350 ахлагч нийт 4590 алба хаагч 640 автомашин, мотоциклтойгоор /хоног 153, ажилласан алба хаагч нэг өдөрт аймагт-6, Тосонцэнгэлд 2, сумдад 18 нийт 26 алба хаагч/ 3970 удаа 23868 хүн/цагийн /хоног, ажилласан алба хаагчийн тоо/ эргүүлийн үүрэг гүйцэтгэж, нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийг хамарсан 155 удаагийн арга хэмжээний үеэр 543 алба хаагч, 1505 цаг, 107 автомашин, 441 тусгай хэрэгсэлтэйгээр хэв журмын хамгаалалтыг зохион байгуулан ажиллалаа.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдон энэ оны эхний 09 сарын байдлаар 476 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгжээр буюу 3,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ оны

эхний 09 сарын байдлаар 96 иргэн баривчлагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3 нэгжээр буюу 8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Баривчлагдсан иргэдийг байранд хүлээн авч, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэн захиргааны туслах тоо бүртгэлийн санд бүртгэж.эрүүлжүүлэх байраар үйлчлүүлсэн хүмүүсийг журмын дагуу картжуулан, шүүх шинжилгээний албатай хамтран 102 хүний биеийн зураг болон хурууны хээг авч санд оруулан, бүртгэл судалгааг тухай бүрд нь баяжуулан ажиллалаа. Ар гэр, асран хамгаалагчид нь 45 хүн хүлээлгэн өгч ажилласан байна.Саатуулагдсан болон баривчлагдсан хүмүүст батлагдсан хуваарийн дагуу сургалтын баг хамтран өдөр бүр Монгол улсын хууль тогтоомжууд, архины хор уршгийн талаар сургалт явуулан зөвлөмж, анхааруулгыг тараан ажилласан. Саатуулах байрны тайлан мэдээг 7 хоног, сар, улирлаар гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Саатуулах баривчлах байрны ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэн ажиллаж байна. Эрүүлжүүлэх, баривчлах байрны хураамж төлбөрийг 100 хувь санхүүтэй тооцоо хийсэн.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар эрүүгийн хэргийн 40, иргэний хэргийн 155, захиргааны хэргийн 13, захиргааны зөрчлийн 22, магадлангийн 6, нийт 236 шүүх хуралдаанд дэг сахиулж ажилласан.

Шүүх хуралд давхардсан тоогоор шүүгч 243, нарийн бичгийн дарга 236, улсын яллагч 65, өмгөөлөгч 67, хохирогч 35 шүүгдэгч 62, хариуцагч 61, нэхэмжлэгч 145, гэрч 4, бусад 7 оролцогч оролцож, шүүх хуралдаан хэвийн явагдсан. Шүүхийн байрны харуул, хамгаалалтын үүргийг 24 цагаар гүйцэтгэж, шүүхийн байранд нэвтэрсэн 2058 иргэдийн бичиг баримтыг шалгаж үйлчилсэн. Харуулын болон хамгаалалтын цагдаа нарт Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргаас үүрэг, ажлын чиглэл 7, зааварчилга 2-г хүргүүлж биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна. Шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор өглөө оройд шүүх танхимуудад үзлэг хийж шүүх хуралд ирж байгаа иргэдийн бичиг баримт, бие эд зүйлд үзлэг хийж хэвшсэн. Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 4 захирамжийг хүлээн авч 1 хариуцагч, 1 хэргийн оролцогч, 2 гэрчийг албадан ирүүлж биелэлтийг хангаж ажилласан. Ердийн хуяглан хүргэх ажиллагааг 13 удаа явуулж аймгийн шүүхэд 0, цагдан хорих байранд 13 иргэнийг хуяглан хүргэснээс 13 удаа авто машинаар хуяглан хүргэх ажиллагааг зохион явууллаа.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Тус Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд 19 санал бүхий 9 танилцуулгыг хүргүүлснээс 81,1 хувийг шийдвэрлүүлсэн ба аймаг, сумдын ГХУСАЗСЗ-ийн хурлаар 9 асуудал хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 224.961.000 төгрөгийг аймаг, сумдын ИТХ, Засаг даргаас гаргуулан шийдвэрлүүлсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 44 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, 83 нэгдсэн үзлэг шалгалт, 174 сургалт мэдээлэл, сурталчилгаа, 10 уулзалт хэлэлцүүлэг, ярилцлага, 11 өдөрлөг, 14 уралдаан тэмцээн нийт 209 ажил арга хэмжээг зохион явуулсан ба эдгээр арга хэмжээнүүдэд 23780 иргэн хамрагдлаа. ГХУС арга хэмжээний хүрээнд 374 иргэн, 315 байгууллагын 2637 ажилтан алба хаагчдыг сайн дурын болон нийтийн эргүүл, жижүүрт ажиллууллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, гарсан гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр 142 байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажиллаа. Мэдэгдлийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй,хариуг хугацаанд нь ирүүлээгүй 5 албан тушаалтанд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцон ажиллаа.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдож болшгүй 86 иргэнийг шинээр бүртгэл судалгаанд хамруулан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол улсын хуульд заасны дагуу цагдаагийн байгууллагын захиргааны хяналтыг 12 хүнд тогтоон ажиллаа. Тус аймагт үйл ажиллагаа ажиллагаа явуулж буй иргэдийн 154 үүсгэл санаачилгын бүлгийн 2680 хүнтэй хамтран ажиллаж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.

Аймаг, сумдын ГХУСАЗСЗ-тэй хамтран Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан 10 байгууллага, 42 иргэнийг 5,652.000 төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Монгол улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, бусад эрх зүйн актууд болон Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд дэвшүүлсэн зорилтыг удирдлага болгон хариуцсан нутаг дэвсгэртээ зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаа.

Замын цагдаагийн алба, Аймгийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд орон нутгийн замд хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэх тээврийн хэрэгслийн шатахууны зардалд 1 сая төгрөгийг 2018 оны 07 дугаар сард шийдвэрлүүлсэн. Мөнх Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Улиастай сумын Засаг даргын нөөц сангаас “Сургууль орчмын бүс” тэмдэг 12 ширхэг нийт зардалд 1,2 сая төгрөгийг шийдвэрлүүлж ажилласан.

Харьяалах дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг ажлын чиглэлийг хэрэгжүүлэх талаар анхаарч хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж ажлын чиглэлүүдийг тухай бүр гарган хүргүүлж ажилласан.

Замын цагдаагийн албаны дэд даргын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 14-1/2948 тоот албан бичгийн хариуг 2018 оны 08 дугаар сарын 23-ны 41/1252 дугаартай албан тоотоор хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд Замын цагдаагийн тасгаас “Мэргэжлийн хяналтын чиглэл“-ээр 2018 оны 06 дугаар сард хийсэн ажлын тайлан мэдээ, Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1-д зааснаар эрхээ хасуулсан иргэдийн бүртгэлийн хамт 2018 оны 08 дугаар сарын 24-ний 41/1257, 41/1258 дугаартай албан тоотоор хүргүүлсэн.

Замын цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Э.Бөхбат, Техник замын хяналтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ч.Жаргалсайхан нарт 2018 оны 08 дугаар сард урьдчилан сэргийлэх, техник замын чиглэлээр хийсэн ажлын мэдээг 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 41/1249, 1250 дугаартай албан тоотоор, Тээврийн цагдаагийн албаны даргын 2018 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 14/52 тоот албан бичгийн хариуг 2018 оны 09 дүгээр сарын 24-ний 41/1501 дугаартай албан тоотоор,Тээврийн цагдаагийн албаны дэд бөгөөд Захиргаа удирдлагын газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний 14/116 дугаартай албан бичгийн хариуг 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр 41/1544 дугаартай албан тоотоор, Тээврийн цагдаагийн албаны Захиргаа удирдлагын газрын төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн даргын 2018 оны 09 дүгээр сарын 10-ний 14-1а/96 дугаартай албан бичгийн хариуг 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр 41/1407 дугаартай албан тоотоор, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 14-2/34 тоот албан бичгийн хариуг 2018 оны 09 дүгээр сарын 13-ны 41/1406 дугаартай албан тоотоор, 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 14-2/65 тоот албан бичгийн хариуг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны 41/1530 дугаартай албан тоотоор,

Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд Замын цагдаагийн тасгаас үнэмлэх нөхөн авах, эрх сэргээх, үнэмлэх солих хүсэлт гаргасан иргэдийн материал хүргүүлэхээр 2018 оны 09 дүгээр сарын 04-ний 41/1340, 2018 оны 09 дүгээр сарын 07-ны 41/1374, 41/1375 2018 оны 09 дүгээр сарын 13-ны 41/1404, 2018 оны 09 дүгээр сарын 19-ний 41/1460, 2018 оны 09 дүгээр сарын 19-ний 41/1461, 2018 оны 09 дүгээр сарын 21-ний 41/1486, 2018 оны 09 дүгээр сарын 21-ний 41/1487 болон “Мэргэжлийн хяналтын чиглэл“-ээр 2018 оны 09 дүгээр сард хийсэн

ажлын мэдээ, Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1-д зааснаар эрхээ хасуулсан иргэдийн бүртгэлийн хамт 2018 оны 09 дүгээр сарын 25-ны 41/1528, 41/1529 дугаартай албан тоотоор хүргүүлсэн.

Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Э.Бөхбат, Техник замын хяналтын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ч.Жаргалсайхан нарт 2018 оны 09 дүгээр сар, 3 дугаар улиралд урьдчилан сэргийлэх, техник замын чиглэлээр хийсэн ажлын мэдээг 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 41/1492, 41/1493 дугаартай албан тоотоор тус тус цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Тус тасаг нь 2018 оны 03 дугаар улиралд сард Тасгийн дарга-1, ахлах зохицуулагч -1, зохицуулагч -3, цагдаа зохицуулагч-15, нийт 20 алба хаагч үүрэг гүйцэтгэж 1 цагдаа зохицуулагчийн орон тоо дутуу, согтуурал шалгагч багаж-2, согтуурал тандагч -5, суурин станц-1, гар станц-13, албаны T.Prius 30 маркийн автомашин-1, Sonata-5 маркийн автомашин-1, YJ-150 маркийн мотоцикл-1 зэрэг техник хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэж ажиллаа.

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр сүүлийн 3 жилд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлд судалгаа хийж осол, хэрэг ихээр гардаг Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн сумдын замд автомашинт эргүүлийг ажилуулан алба хаагчдын ажлын хуваарьт өөрчлөлт хийж Цагдаагийн газрын даргаар батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 12830 тээврийн хэрэгсэл шалгаж 3181 зөрчил илрүүлж, Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1, 5 дахь заалтуудыг зөрчиж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 79 жолоочийг илрүүлэн тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаанд саатуулж ажилласан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 54 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаатайгаар хасаж, хуульд заасны дагуу тус бүр 400.000 төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 25 иргэнийг сум дундыг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр 7-14 хоногоор баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэж ажиллаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Замын хөдөлгөөний дүрэм, бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн эрхийн үнэмлэхгүй болон ангилал бус тээврийн хэрэгсэл жолоодсон болон бусад заалт зөрчсөн 93 иргэнийг шийтгэлийн хуудсаар 2.825.000 төгрөгөөр торгож, нийт 3159 жолоочийг 102.955.000 төгрөгөөр торгож, зөрчил гаргасан 117 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулсан тээврийн хэрэгслийн эзэмшигчдээс түр саатуулсан хашааны хураамж 364.400 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлж ажилласан

Цагдаагийн нийтлэг үүргээр: Цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Р.Мөнхбаатар 2018.08.18-ны өдөр эрүүгийн цагдаагийн тасгаас эрэн сурвалжилж байсан HR-V маркийн 44-66 ЗАА улсын дугаартай автомашиныг илрүүлэн ЭЦТасагт шилжүүлсэн Цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Ц.Гантулга 2018.09.21,23-ны өдрүүдэд Atlas маркийн 78-39 ЗАА, Mighty маркийн 30-41 ЗАН улсын дугаартай тээврийн хэрэгслүүд зохих зөвшөөрөлгүй мод тээвэрлэсэн зөрчлийг илрүүлж Тосонцэнгэл сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах тасаг харьяаллын дагуу шилжүүлж ажилласан. Мөн 2018.09.21-ний өдөр ASAP сангаас Улаанбаатар хот БЗД-ийн ИХАШШүүхээс эрэн сурвалжилж байсан Г.Ганхуягийг илрүүлж БЗД-ийн Цагдаагийн 2-р хэлтсийн мөрдөгч Х.Оюунболдод хүлээлгэж өгсөн.

Цагдаагийн газрын шуурхай удирдлагын төвийн 7046102 дугаарын утсанд иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн зам тээврийн ослын 18 гомдол, мэдээлэл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам/код202/-ын дагуу хүлээн авснаас захиргааны арга хэмжээ

авсан 16 зохицуулагч нар шийдвэрлэж, шуурхай албаны бүрэлдэхүүний хамт зам тээврийн осол, хэргийн шинжтэй гомдол мэдээлэлд ослын газрын үзлэг хэмжилт хийж ажилласан байна.

Осол хэргийн улмаас нас барсан 2, гэмтсэн 4, иргэд, аж ахуй нэгж байгууллагад 10265568 төгрөгийн хохирол учирснаас зөрчлийг шалгах шатанд хохирлыг даатгалын байгууллагад тодорхойлолт гаргаж 100% хувь нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд дайран өнгөрч байгаа улсын чанартай хатуу хучилттай авто замуудын зам тээврийн осол, ихээр гардаг хар цэгүүдэд хөдөлгөөнт эргүүл ажиллуулснаар осол хэргээс урьдчилан сэргийлж дээрх хар цэгүүдэд хүн нас барсан хэрэг, осол бүртгэгдээгүй байна.

Дээрх осол ихээр гардаг цэгүүдэд техник замын хяналтын болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөдөлгөөний эрчим ихтэй цаг, гарагт хөдөлгөөнт эргүүлийг тогтмолжуулан тодорхой цагуудад ажиллуулж хэвшээд байна.

Улсын хэмжээнд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цагдаагийн байгууллагаас явуулж буй ажил, арга хэмжээг иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор Монгол улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн алба хамтран зохион байгуулж байгаа “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл-2018”, “Оюутан тээвэр-2”, “Ургац-2018”, “Хичээлийн шинэ жил” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэртээ зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд Завхан аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас салбар төлөвлөгөө гарган тасгийн дарга, цагдаагийн хошууч М.Лхагвадорж алба хаагчдад танилцуулж зааварчилгаа өгч, гудамж, замд үүрэг гүйцэтгэх үед иргэдтэй харьцахдаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хууль дээдлэх, хүнлэг энэрэнгүй ёсыг эрхэмлэн, Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандартыг баримталж ажиллахыг амаар болон бичгээр үүрэг өгч, баталгаа гаргуулж, алба хаагчдын хувийн болон албаны бэлэн байдлыг ажилд гарахаас өмнө ахлах зохицуулагчаар шалгуулан зааварчилгааг танилцуулж гарын үсэг зуруулан ажиллаж байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Завхан аймгийн Цагдаагийн газар”, “Орон нутгийн замын цагдаа” facebook цахим хаягаар олон нийтэд арга хэмжээний талаар мэдээ, мэдээлэл 65 нийтэлж иргэдэд хүргэж, Орон нутгийн “Шинэ Завхан” телевиз, радио Fm 106,5-тай хамтран иргэд жолооч нарыг орон нутгийн замд зорчихдоо хамгаалах бүсээ тогтмол хэрэглэж хүүхдийг зориулалтын суудал дээр сууж байх талаар болон бороо орсны улмаас замын зорчих хэсэг эвдрэх,09 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд Их-Уул сумын Солонготын даваанд цас орж халтиргаа гулгаа үүссэн талаар иргэд, жолооч сэрэмжлүүлэг давхардсан тоогоор 30 удаа сэрэмжлүүлэг өгч, телевизийн урсдаг зар хэлбэрээр сэрэмжлүүлгийг өдөр бүр тогтмол иргэдэд хүргэж ажиллаж байна.

“Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2018”, “Оюутан тээвэр-2”, ”Ургац-2018”, “Хичээлийн шинэ жил” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд иргэдэд арга хэмжээний ач холбогдол болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд Air-1 радио Fm 106,5, “Шинэ Завхан” телевизээр мэдээлэл хүргэж ажиллаа.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газрын хүлээлгийн танхимын телевиз, Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг Жавхлант хийморь хоршооны 15 автобусны заалны дэлгэц, Хаан банк, Төрийн банк, Скайтал зэрэг аж ахуйн нэгжүүдийн сурталчилгааны дэлгэцээр “Таны хүүхэд хаана байна вэ”, “Хамгаалах бүс таныг хамгаална” зэрэг 12 төрлийн богино хэмжээний видо сэрэмжлүүлэг тогтмол гарч иргэдэд сэрэмжлүүлэг өгч ажиллаж байна.

Зам тээврийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн баяр наадмын өдрүүдээр нийт 1500 ш санамж сэрэмжлүүлэг, мөн “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2018” хүрээнд 4 төрлийн 500 ш санамж, ”Оюутан тээвэр-2” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2 төрлийн 1000 ширхэг нийт 3000 санамж сэрэмжлүүлгийг сэрэмжлүүлэгийг бэлтгэн жолооч, зорчигч нарт тарааж “Жавхлант хийморь”, “Грандавтобус”

ХХК хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллаагаа эрхэлдэг автобуснуудын суудлын арын хэсэгт Зорчигчийн үүрэг болон Зөрчлийн тухай хуулиар санамж сэрэмжлүүлэг 675 ширхэгийг хэвлүүлэн суудлын арын хэсэгт байрлуулж ажиллаа.

Арга хэмжээний хүрээнд хот хоорондын зорчигч тээвэр үйлчилгээ эрхэлдэг "Жавхлант хийморь", “Гранд автобус”, "Жигд эргэлт" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслүүдийн техникийн байдал, багаж хэрэгсэл, хяналтын камер /хар хайрцаг/-т үзлэг шалгалт хийж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, үйлчилгээний стандартыг хангуулах, зорчигч иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 25 жолоочид зааварчилга өгч ажиллаа.

Мөн УИХ-ийн гишүүн, УИХ-ийн дэд дарга Я. Санжмятавын санаачлан зохион байгуулсан “Бид Чингисийн үр сад, зөв тэмүүлэл, эх оронч манлайлал” арга хэмжээ 2018 оны 09 дүгээр сарын 05-наас мөн сарын 20-ны өдрүүдэд Улиастай, Их-Уул, Тосонцэнгэл, Сонгино, Шилүүстэй, Түдэвтэй, Баянтэс, Тэс сумдад бүсчлэн зохион байгуулагдаж арга хэмжээний хүрээнд хүүхэд тээвэрлэх 22 сумын 85 автомашин, “Жавхлант хийморь хоршоо”, “Гранд автобус”, “Жигд эргэлт” ХХК-ний 25 автобус нийт 110 жолооч нарт Монгол улсын замын хөдөлгөөний дүрмээр сургалтыг хэсэгчлэн зохион байгуулж, тээврийн хэрэгслүүдэд үзлэг шалгалт хийж хүүхэд тээвэрлэх үеийн цувааны хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулж ажиллаа.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Нөмрөг сумын 45 иргэн, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг “Жавхлант хийморь”, “Гранд автобус” ХХК-ны 18 жолооч нарт болон эрх сэргээх шалгалтад орохоор ирсэн 55 иргэнд цагдаагийн ахмад Г.Алтаншагай Зөрчлийн хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар, “Бид Чингисийн үр сад, зөв тэмүүлэл, эх оронч манлайлал” арга хэмжээ хүрээнд цагдаагийн ахлах дэслэгч П.Эрдэнэбаяр хүүхэд тээвэрлэх 110 жолооч нарт хэсэгчилсэн сургалт зааварчилга, цагдаагийн хошууч М.Лхагвадорж аймгийн ЗДТГ-ын дарга болон бусад албадын мэргэжилтнүүдтэй Төрийн үйлчилгээг багт арга хэмжээний хүрээнд Сонгино, Сантмаргаз, Цэцэн-Уул, Алдархаан сумдын багуудаар уулзалт зохион байгуулж уулзалтаар Завхан аймагт гарч буй зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөл, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх болон Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар сургалт зохион байгуулж уг арга хэмжээнд 32 багийн 2563 иргэнд, нийт 2791 иргэд жолооч нарт сургалт зохион байгуулж ажиллаа.

Замын цагдаагийн тасгаас “Хичээлийн шинэ жил” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 08 дугаар сарын 30-наас 09 дүгээр сарын 03-ны хооронд зохион байгуулж арга хэмжээний хүрээнд Улиастай сумын ЗДТГ болон Зэсийн бүрд ХХК хамтран Улиастай сумын ерөнхий боловсролын Дэвшил, Жавхлант цогцолбор сургуулийн бүсэд “Сургуулийн орчмын бүс” тэмдэг байрлуулж 4 хурд сааруулагчийг стандартын дагуу болгож засварлан явган хүний гарцын тэмдэглэгээ 3-г сэргээж, хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааны хамгаалалт зохицуулалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудтай 2018-2019 оны хичээлийн шинэ жилд хамтран ажиллах гэрээ байгуулж, орон нутгийн Шинэ Завхан телевизээр сурталчилж ажиллаа.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх тодорхой төрлийн зөрчлийг арилгуулах зорилгоор 7 дугаар сард Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний алба, Гранд автобус ХХК-д албан мэдэгдэл 6, 8 дугаар сард Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний алба, “Хурдны зам” ХХК, Богдын голын усан цахилгаан станц ТӨХК зэрэг 3 албан байгууллагад мэдэгдэл 4, 9 дүгээр сард “Хичээлийн шинэ жил” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 19 захирал, эрхлэгч нарт 2018-2019 оны хичээлийн шинэ жил эхлэх гэж байгаатай холбогдуулан 5 чиглэлийн үйл ажиллагаа зохион байгуулах талаар, 2018 оны 08 дугаар сарын 24-ний өдөр 41/100, Алтай- Улиастай эрчим хүч ТӨХК-нд Улиастай сумын Жаргалант багийн нутагт байрлах замын зорчих хэсэг дээгүүр байрлах гэрлийн утас унжиж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулж байгааг засварлах талаар 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдөр 41/101, Улиастай сумын Засаг даргад Улиастай сумын ерөнхий боловсролын сургуулиудын бүсэд “сургуулийн орчмын бүс” тэмдэг байрлуулж гарцын тэмдэглэгээг сайжруулах, хурд сааруулагчийг стандартын дагуу болгож ХАБ-ыг хангуулах тухай 2018.08.28-ний өдөр

41/104, Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний албанд замын гэрэлтүүлгийг сайжруулах асахгүй байгаа гэрлүүдийг засварлах зөрчлийг арилгуулах тухай 2018 оны 08 дугаар сарын 28-нд 41/105, Улиастай сумын Чигэстэй багийн Засаг дарга Б.Чимэдцэрэнд багийн иргэдэд зам тээрийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж ажиллах талаар 2018 оны 9 дүгээр сарын 04-нд 41/106, мөн сарын 12-нд 41/109 дугаартай мэдэгдлүүдийг тус тус хүргүүлж хариу авалт 80 хувьтай байна.

Цаашид Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж Замын цагдаагийн алба болон Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг орон нутгийн хэмжээнд үр дүнтэй зохион явуулж хийж хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээний талаар аймгийн “Шинэ Завхан” телевиз, “AIR-1” радио FM-106.5 –аар тогтмол мэдээ, мэдээлэл өгч Завхан Цагдаагийн газар, Орон нутгийн замын цагдаа, Завхан нэгдсэн групп facebook хаягаар иргэд олон нийтэд тогтмол сурталчлан ажилласан.

Одоогоор тус аймагт шинээр баригдаж байгаа Тосонцэнгэлээс Тэлмэн сумын чиглэл, Дөрвөн замаас Сонгино сумын чиглэлийн зам засварын ажил хэвийн явагдаж байгаа бөгөөд бороо их орсны улмаас Солонготын даваа, Загастайн даваа, Ганцын дабааны замуудад эвдрэл их гарч байгаатай холбогдуулан замын засвар арчлалтад давхардсан тоогоор 2 удаа хяналт тавьсан. Улиастай сумын зам дагуух болон гэр хороолол, гудамж талбайд асаж байгаа гэрэлтүүлэгт өдөр бүхэн хяналт тавин ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалтын хувь 89%-тай байгаа. Хот тохижилт үйлчилгээний албанд Жинст, Жаргалант, Богдын гол, Товцог багуудын замын зорчих хэсгийн явган хүний гарцын тэмдэглэгээг сайжруулж будах талаар мэдэгдэл өгсөн. “Хичээлийн шинэ жил” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 08 дугаар сарын 30-наас 09 дүгээр сарын 03-ны хооронд зохион байгуулж арга хэмжээний хүрээнд Улиастай сумын ЗДТГ-аас 1,2 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж Улиастай сумын ерөнхий боловсролын “Дэвшил”, “Жавхлант” цогцолбор сургуулийн бүсэд “Суруулийн орчмын бүс” тэмдэг 8, “явган хүний гарц” тэмдэг 4-ийг байрлуулж, “Зэсийн бүрд” ХХК өөрийн санаачлагаар 4 хурд сааруулагчийг стандарын дагуу болгож засварлан явган хүний гарцын тэмдэглэгээ 3-ийг сэргээж, ажиллаа. Цаашид “Чандмань-Эрдэнэ” лабортори сургууль, Бүрэн дунд 3-р сургууль, 4-р сургуулиудын бүсд тэмдэг, тэмдэглэгээг суурилуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Завхан аймаг байгуулагдсаны түүхт 96 жил, Ардын хувьсгалын 97 жилийн ойн баяр наадмын үеийн хамгаалалтад Замын цагдаагийн тасгийн дарга 1, ахлах зохицуулагч 1, зохицуулагч 2, Цагдаа зохицуулагч 9, нийт давхардсан тоогоор 26 албан хаагч 2 тээврийн хэрэгсэл, 2 суурин станц, 10 гар станц ашиглан 2018.07.09-ний өдрөөс 2018.07.11-ний өдрийг хүртэл Завхан аймгийн Алдархаан сумын нутаг Донойн хөндий гэх газраас Улиастай сум хүртэл 32 км замд үүрэг гүйцэтгэж хамгаалалт зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Завхан аймаг Тосонцэнгэл сумд 2018 оны 09 сарын 18-ны өдөр Улаанбаатар хотоос Завхан аймаг, 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Завхан аймгаас Улаанбаатар хотын чиглэлд ирж буцах үеийн дамжин өнгөрөх үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /Код 500/ Нийтийн хэв журам Хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах /,Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах журам/код 506/-ыг хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтыг зохион байгууллаа.

Хамгаалалтын цуваг 2018 оны 09 сарын 18-ны өдрийн 16:10 цагт Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа С.Цэрэнсамбуу 60-09 ЗАН улсын дугаартай Landcruiser-77 маркийн тээврийн хэрэгсэлтэй тосон авч Солонготын дабааны Ар ганга гэх газар ирэх үед Замын цагдаагийн тасгийн зохицуулагч, цагдаагийн ахмад Г.Алтаншагай, Б.Жадамба, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Н.Пүрэвтэгш нар хамгаалалт зохицуулалт хийж 18:10 цагт Завхан аймаг Их-уул сумын Цэц-Үүх багт ирэх үед хамгаалалтад цагдаагийн ахлагч Э.Очирхүү, Б.Баатарсүх, Ц.Гантулга, цагдаагийн дэд ахлагч С.Дэмчиг нар ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Завхан аймгийн Улиастай сумд ажиллах үед хамгаалалтад 3 офицер, 8 ахлагч 1 тээврийн хэрэгсэлтэйгээр хамгаалалтыг зохион байгуулж ажиллаа

Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн дэд хурандаа Ч.Уранбор тасгийн албаа хаагч нарт гудамж замд хяналт шалгалт хийж ажиллахдаа аюулгүй байдлаа ханган ажиллах талаар зааварчилгааг 7 хоног бүр томилгооны хамт танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулж хэвшсэн.

Гурав. Дүгнэлт

Цаашид Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд дэвшүүлэн зорилт, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө мөн дээд байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн үүрэг, чиглэл, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг нэмэгдүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулж, албаа хаагч бүрийн ажлын хариуцлага, сахилга, ёс зүйг сахин хангаж Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн баталсан удирдамжийн дагуу хийгдсэн төлөвлөгөөт шалгалтын дүнг хэлэлцээд Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд, Дэд дарга нараас болон ажлын хэсгээс өгсөн үүрэг чиглэл, ажлын зааварчилгааг бүрэн хэрэгжүүлэн шуурхай, хуульч ажиллагааг хэвшүүлэн ажиллана.

Дөрөв. Санал

1. 2018 оны эхний 6 сарын байдлаар аймгийн хэмжээнд согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн болон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ захиргааны зөрчилд холбогдсон 333 хүн эрүүлжүүлэгдэж, 120 иргэн захиргааны журмаар баривчлагдсан байна. Тус цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байр нь эмч-4, цагдаа-4, тогооч-1, Тосонцэнгэл сумд эмч-1, цагдаа-4 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа 24 цагаар тасралтгүй явуулж байна. Иймд цагдаагийн газрын болон Тосонцэнгэл сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр удирдан зохион байгуулж ажиллах зорилгоор Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмчийн 1 орон тоог дарга-эмчийн орон тоо болгон өөрчлүүлэх,
2. Албаа хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий албаа хаагчдыг нийслэлд нэг сарын хугацаатайгаар сэлгэн ажиллуулах,
3. Цагдаагийн газрын тээвэр шатахууны зардал нь сумдын хэсгийн төлөөлөгч нар Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч шалгахад 3 хоног дотор шийдвэрлэх, өвлийн улиралд Отгон, Шилүүстэй, Тэс, Баянтэс зэрэг сумд нь даваа хаагдсанаас батлагдсан замаас 80-250 км тойруу замаар явах, дулааны улиралд Завханмандал, Ургамал, Дөрвөлжин, Цэцэн-Уул зэрэг сумд нь хэрэг шалгах явцад элс ихтэйн улмаас 120-200 км тойрч явах зэргээс шалтгаалан шатахууны зардал нэмэгдэж байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/259 тушаалаар 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа албаа хаагчдын хоолны зардлын хэмжээг 40 хувиар нэмж 5000 /таван мянга/ төгрөгөөр тогтоосон боловч энэ оны төсөвт хоолны зардал нэмэгдээгүйн улмаас өглөг үүссэн зэрэг асуудлыг шийдвэрлүүлэх саналтайг илтгэн танилцуулъя.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА С.ЦЭРЭНСАМБУУ